Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

# ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт-гэлийн хувь | ХШҮ-ний хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | | |
| **СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 2. ХУУЛЬ ЁСЫГ САХИУЛЖ, ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГЫГ САЙЖРУУЛНА** | | | | | | | | | |
| **Стратегийн зорилт 2.1 Засгийн газрын хяналт, шалгалтын үйл ажиллагааны үр нөлөө дээшилсэн байна** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 2.1.1 Засгийн газрын хяналт шалгалтын үйл ажиллагааг хууль, журамд нийцүүлэн хийж, үр дүнг тайлагнах** | | Улсын төсөв | хэрэгжилтийн хувь | - | | | | **73.5** | **73.5** |
| 1 | Арга хэмжээний 2.1.1.1-т тусгагдсан ажлын хүрээнд: Хяналт шалгалтын үр дүнд үндэслэн хууль тогтоомж, бодлого шийдвэр, дүрэм, журам, стандартыг шинэчлэх, нэмэлт өөрчлөлт оруулах талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд санал, зөвлөмж хүргүүлэх. | Улсын төсөв | Санал, зөвлөмжийн тоо | 25 | 13 | 13 | Хяналт шалгалтын хүрээнд хууль тогтоомж, дүрэм журмыг өөрчлүүлэх чиглэлээр 6 санал зөвлөмж хүргүүлсэн. Үүнд:<br>1.Нийслэлийн шүд, эрүү, нүүрний төвд хийсэн хяналт шалгалтын үр дүнг үндэслэн Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэнд 2026 оны 01/268 дугаартай албан бичгээр Нийслэлийн шүд, эрүү нүүрний төвийн үйл ажиллагаанд хэрэгжиж байгаа дүрмийг дахин боловсруулж батлан мөрдүүлэх; | 47 | 47 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2. Нийслэлийн шүд, эрүү, нүүрний төвд хийсэн хяналт шалгалтын үр дүнг үндэслэн Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэнд 2026 оны 01/268 дугаартай албан бичгээр Эрүүл мэндийн салбарын эмч, сувилагч, захиргааны ажилтан албан хаагчдыг сонгон шалгаруулах нийтлэг журмыг шатлал бүрд тохируулан боловсруулж батлан мөрдүүлэх;<br><br>3.Нэр бүхий иргэнээс гаргасан гомдлыг шалган шийдвэрлэсэн дүнг үндэслэн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд 2026 оны 01/365 дугаар албан бичгээр "Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрх олгох сонгон шалгаруулалтад оролцогчдоос төсөл хүлээн авах журам"-ыг хэрэгжүүлж ажиллах, шинэчлэн боловсруулах;<br><br>4.Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэнгийн зарим үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүнг үндэслэн Шинжлэх Ухааны Академийн ерөнхийлөгчид 2026 оны 02/664 дүгээр албан бичгээр "Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгийн захирлыг сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх журам"-ыг хууль, тогтоомжид нийцүүлэх;<br><br>5.Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаанд хийсэн Хяналт шалгалтын тайлангаар Боловсролын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сайдад “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээл эргэн төлүүлэх журам”-д өөрчлөлт оруулах;<br><br>6.Дархан-Уул аймгийн Засаг даргын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүнг үндэслэн тус аймгийн Засаг даргад 2026 оны 01/02 дугаар албан шаардлагаар ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах, “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг баталж, мөрдүүлэх; | | |
| 2 | Арга хэмжээний 2.1.1.2-т тусгагдсан ажлын хүрээнд: Засгийн газар, Ерөнхий сайд, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаас өгсөн үүрэг, шийдвэр, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу Монгол Улсыг олон улсад сурталчлах ажлын хүрээнд байгуулсан зарим гэрээний хэрэгжилтийн үр дүнд хяналт шалгалт хийх | Улсын төсөв | Албан шаардлага, мэдэгдлийн тоо | - | 2 | 3 | Засгийн газар, Ерөнхий сайд, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаас өгсөн үүрэг, шийдвэрийн дагуу 7 хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br><br>1.Монгол Улсыг олон улсад сурталчлах ажлын хүрээнд байгуулсан нэр бүхий 3 гэрээний хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын дүнг үндэслэн Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн биелэлтийг дүгнэж, Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.<br><br>2.Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сайдаас өгсөн үүргийн дагуу Ерөнхий хянан шалгагчийн баталсан 2026 оны 01/03 дугаар удирдамжийн хүрээнд Дархан-Уул аймгийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүнг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын тэрүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдад танилцуулсан.<br><br>3.Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаас өгсөн үүргийн дагуу Ерөнхий хянан шалгагчийн баталсан 2026 оны 01/04 дүгээр удирдамжийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүнг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын тэрүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдад танилцуулсан.<br><br>4.Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдаас өгсөн үүргийн дагуу Ерөнхий хянан шалгагчийн баталсан 2026 оны 01/04 дүгээр удирдамжийн хүрээнд Алтанбулаг чөлөөт бүсийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүнг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын тэрүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад танилцуулсан.<br><br>5.Засгийн газрын хуралдаанаас өгсөн үүргийн дагуу “Туулын хурдны зам” төслийн зарим үйл ажиллагаанд Ерөнхий хянан шалгагчийн 2026 оны | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 01/06 дугаар удирдамжийн хүрээнд хяналт шалгалт хийж, дүнг Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.<br><br>6.Засгийн газрын хуралдаанаас өгсөн үүргийн дагуу Засгийн газрын 2026 оны 127 дугаар тогтоолын хэрэгжилтэд Ерөнхий хянан шалгагчийн баталсан 2026 оны 01/05 дугаар удирдамжийн хүрээнд нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүнг Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанд танилцуулсан.<br><br>7.Засгийн газрын хуралдаанаас өгсөн үүргийн дагуу ЗГХЭГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр хийгдсэн гэрээний хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, дүнг Засгийн газрын 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. | | |
| **Стратегийн зорилт 2.2 Хяналт, үнэлгээ, мониторинг, тандалт судалгааны үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн байгууллагын оролцоо нэмэгдсэн байна** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 2.2.1 Иргэд, олон нийтийн байгууллага, мэргэшсэн зөвлөхүүдтэй хамтран ажиллах** | | **Улсын төсөв** | **Хэрэгжилтийн дундаж хувь** | - | 50% | 100% | | 100 | **75** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Арга хэмжээний 2.2.1.1-т тусгагдсан ажлын хүрээнд: Хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд төрийн болон бусад байгууллагын төлөөлөл, мэргэжилтэн, шинжээч оролцуулах | Улсын төсөв | Хамтран гүйцэтгэсэн хяналт шалгалтын тоо | - | 1 | 1 | Хяналт шалгалтад төрийн болон бусад байгууллагын төлөөлөл, мэргэжилтэн, шинжээч оролцуулах нөхцөл, шаардлага одоогоор үүсээгүй. | - | - |
| 4 | Арга хэмжээний 2.2.1.5-т тусгагдсан ажлын хүрээнд: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын чиг үүрэгт хамаарах асуудлаар хүн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдол, мэдээллийг шийдвэрлэх, шаардлагатай гэж үзвэл хяналт шалгалт хийх | Улсын төсөв | Хяналт шалгалтын тоо | 13 | 6 | 7 | Иргэн, хуулийн этгээдээс 221 өргөдөл, гомдол, үүнээс гомдол 170, санал 6, хүсэлт 43, талархал 2-ыг тус тус ирүүлсэн. Ирүүлсэн өргөдөл гомдлын 186-ыг нь хуулийн хугацаанд, 2-ыг нь хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн, 33 өргөдөл, гомдол хяналтад байна.<br><br>Мөн өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу 2 хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн дүнг танилцуулсан бөгөөд 2 хяналт шалгалтыг хийж байна. Үүнд:<br><br>1.Өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу Нийслэлийн шүд, эрүү, нүүрний төвийн зарим үйл ажиллагаанд ахлах хянан шалгагчийн баталсан 02/01 дүгээр удирдамжийн хүрээнд хяналт шалгалт хийж дүнг удирдамжид заасан хугацаанд танилцуулсан бөгөөд ахлах хянан шалгагчийн 02/01 дүгээр албан шаардлагыг хүргүүлсэн.<br><br>2.Өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу ШУА-ийн Философийн хүрээлэнгийн зарим үйл ажиллагаанд ахлах хянан шалгагчийн 02/07 дугаар | 100 | 80 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж, дүнг удирдамжид заасан хугацаанд танилцуулж, ШУА-ийн ерөнхийлөгчид ахлах хянан шалгагчийн 02/05 дугаар албан шаардлагыг хүргүүлсэн.<br><br>3.Өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн зарим үйл ажиллагаанд Ерөнхий хянан шалгагчийн баталсан 01/08 дугаар удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж байна.<br><br>4.Өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны зарим үйл ажиллагаанд ахлах хянан шалгагчийн баталсан 02/09 дүгээр удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж байна. | | |
| 5 | Арга хэмжээний 2.2.1.6-т тусгагдсан ажлын хүрээнд: Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газраас ирүүлсэн эрсдэлийн шинжилгээний үр дүнд үндэслэн яам, аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх | Улсын төсөв | Албан шаардлага, мэдэгдлийн тоо | - | | 1 | Тандалт судалгаа, бодлого төлөвлөлтийн газраас ирүүлсэн эрсдэлийн шинжилгээний үр дүнд үндэслэн Сүхбаатар, Хөвсгөл аймгийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр төлөвлөгөөг газрын дарга бөгөөд Ерөнхий хянан шалгагчаар батлуулсан. Хяналт шалгалт хийгдэх хугацаа болоогүй байна. | - | - |
| 6 | Арга хэмжээний 2.2.1.7-т тусгагдсан ажлын хүрээнд: Засгийн газар дахь хяналт шалгалтын ажлын 2025 оны ерөнхий дүнг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд | Улсын төсөв | Танилцуулсан тайлангийн тоо | - | 1 | - | Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т заасны дагуу Засгийн газар дахь хяналт шалгалтын ажлын 2025 оны ерөнхий дүнгийн танилцуулгыг бэлтгэн Ажлын хэсгийн ахлагч болон | 100 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Ерөнхий сайд, Улсын Их Хуралд танилцуулахад бэлтгэх | | | | | | Үнэлгээ, мониторингийн газарт хүргүүлсэн. | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 2.2.2 Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн бодит үр дүнг нэмэгдүүлэх** | | **Улсын төсөв** | **Нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь** | - | 100% | 100% | | 100 | **100** |
| 7 | Арга хэмжээний 2.2.2.3.4-т тусгагдсан ажлын хүрээнд: Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 15.5-д заасан гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх, Хяналт шалгалт хийсэн талаарх дүнг үндэслэн Ахлах хянан шалгагч, Ерөнхий хянан шалгагчийн мэдэгдэл, албан шаардлагыг хүргүүлж, биелэлтэд хяналт тавих | Улсын төсөв | Хяналт шалгалтын тоо | 3 | 3 | 4 | Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэгт заасны дагуу гүйцэтгэлийн хяналт шалгалт 1-ийг хийж гүйцэтгэсэн.<br><br>1.Ерөнхий хянан шалгагчийн 2025 оны 01/51 дүгээр албан шаардлагын биелэлтэд Ерөнхий хянан шалгагчийн 2026 оны 01/02 дугаар удирдамжийн дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт 2026.02.09-ний өдрөөс 2026.02.12-ны өдрийн хугацаанд гүйцэтгэлийн шалгалтыг хийж, дүнг танилцуулсан.<br><br>Мөн 5 албан шаардлагыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн. Үүнд:<br><br>1.Хяналт шалгалтын дүнг үндэслэн нийслэлийн шүд, эрүү нүүрний төвийн даргад зөрчлийг арилгах 13 заалт бүхий ахлах хянан шалгагчийн 2026 | 100 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оны 02/01 дүгээр албан шаардлагыг хүргүүлсэн.<br>2.Хийж, гүйцэтгэсэн хяналт шалгалтын дүнг үндэслэн Дархан-Уул аймгийн Засаг даргад зөрчлийг арилгах 14 заалт бүхий 2026 оны 01/02 дугаар албан шаардлагыг хүргүүлсэн.<br>3.Хийж, гүйцэтгэсэн хяналт шалгалтын дүнг үндэслэн Сэлэнгэ аймгийн Засаг даргад зөрчлийг арилгах 21 заалт бүхий 2026 оны 01/03 дугаар албан шаардлагыг хүргүүлсэн.<br>4.Хийж, гүйцэтгэсэн хяналт шалгалтын дүнг үндэслэн “Алтанбулаг” чөлөөт бүсийн захирагчид зөрчлийг арилгах 8 заалт бүхий 2026 оны 01/04 дүгээр албан шаардлагыг хүргүүлсэн.<br>5.Хийж гүйцэтгэсэн хяналт шалгалтын дүнг үндэслэн Шинжлэх Ухааны Академийн ерөнхийлөгчид зөрчлийг арилгах 1 заалт бүхий 02/05 дугаар албан шаардлагыг хүргүүлсэн. | | |
| **5. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | | | |
| **Гүйцэтгэлийн зорилт 5.1 Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлага, манлайллыг хэрэгжүүлэх** | | **Улсын төсөв** | **Арга хэмжээний хэрэгжилтийн хувь** | 1 | 100% | 100% | | 100 | **80** |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | Арга хэмжээний 5.1.4-т тусгагдсан ажлын хүрээнд: Монгол Улсын Тэргүүн Шадар сайд, байгууллагын удирдлагыг цаг үеийн мэдээ, мэдээллээр хангах, мэргэшлийн болон арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах | Улсын төсөв | Гүйцэтгэлийн хувь | - | 100% | 100% | 1.Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 3,<br>Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга бөгөөд Ерөнхий хянан шалгагчид 9 хяналт шалгалтын явц болон дүн, тайланг танилцуулан шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж, өгсөн үүрэг чиглэлийг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэсэн. | 100 | 80 |
| 9 | **Гүйцэтгэлийн зорилт 5.2 Байгууллагын өдөр тутмын хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, архив, албан хэргийг хөтлөх** | **Улсын төсөв** | **Арга хэмжээний хэрэгжилтийн хувь** | - | 100% | 100% | | 100 | **100** |
| 10 | Арга хэмжээний 5.2.1-т тусгагдсан ажлын хүрээнд: Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хариутай албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хөтлөгдөж дууссан баримт бичгийг архивлаж, архивд хүлээлгэн өгөх | Улсын төсөв | Албан бичиг, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь | 100% | 100% | 100% | Өргөдөл, гомдлыг шалган шийдвэрлэх хүрээнд цугласан баримт бичиг болон хяналт шалгалтын материал 256 боть архивын нэгжийг Тамгын газарт хүлээлгэж өгсөн. | 100 | 100 |
| | | | Хугацаандаа архивд хүлээлгэн өгсөн эсэх (тийм-1, үгүй-0) | - | 1 | | | 100 | 100 |
| 11 | Арга хэмжээний 5.2.2-т тусгагдсан ажлын хүрээнд: Архив албан хэрэг хөтлөлтийн цахим архивын систем нэвтрүүлэх | Улсын төсөв | Цахим архивын систем нэвтрүүлсэн эсэх | - | 1 | | Тайлагнах хугацаа болоогүй. | - | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | (тийм-1, үгүй-0) | | | | | | |
| НИЙТ ҮНЭЛГЭЭ /ХУВЬ/ | | | | | | | | | 85.7 |

*Төлөвлөгөөг үнэлсэн:* **Төсвийн шууд захирагч**

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ДАРГА ............................... П.БАТБААТАР
*(албан тушаал)* *(гарын үсэг)* 2026.6.10 ................... *(огноо)*

9023010230 СТС3950 6976747

*Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:* **Нэгжийн дарга**

ДОТООД ХЯНАЛТ, АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ........................... Р.ДЭЖИД
*(албан тушаал)* *(гарын үсэг)* 2026.06.16 ..................... *(огноо)*

*Тайлагнасан:* **Нэгжийн дарга**

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ДАРГА .................................... Б.БАЯСГАЛАН
*(албан тушаал)* *(гарын үсэг)* .................... *(огноо)*